



ЭХ, НЯРАЙ, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН  
ҮНДЭСНИЙ ТӨВ ХОЁРТ

## МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,  
Утас/факс: (976-51) 26 74 68, И-мэйл: info@mof.gov.mn  
Вэбсайт: www.mof.gov.mn

2023.03.27 № 03/1715  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Гүйцэтгэгч сонгох ажиллагааг түр  
түдгэлзүүлэх тухай

Танай байгууллагаас зарласан ЭНЭҮТ2/202301015 дугаартай “Эмчилгээний өрөөний тавилга хэрэгсэл /ком/”, ЭНЭҮТ2/202301014 дугаартай “Эмнэлгийн тавилга /ширээ, сандал” нийлүүлэгчийг сонгох тендер шалгаруулалтуудад оролцсон “Био реажент” ХХК-аас Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн 55 дугаар зүйлийн 55.1 дэх хэсэгт заасны дагуу гомдол гаргасан байна.

Хуулийн 55 дугаар зүйлийн 55.4 дэх хэсэг, Сангийн сайдын 2019 оны 131 дүгээр тушаалаар баталсан “Тендерт оролцогчдоос ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэх журам” /цаашид “журам” гэх/-ын 4.6 дахь заалтад тус тус үндэслэн захиалагчийн шийдвэр буюу үйлдлийн хэрэгжилтийг 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн түр түдгэлзүүлж байна. Иймд гомдлыг хянан шийдвэрлэхэд шаардлагатай дараах баримт бичгийг 2023 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн дотор ирүүлнэ үү. Үүнд:

1. Батлагдсан төсөвт өртгийн шийдвэрийн хуулбар;
2. Захиалагчийн үнэлгээний хороо томилсон шийдвэр;
3. Үнэлгээний хорооны гишүүдийн АЗ гэрчилгээний хуулбар;
4. Захиалагчийн баталсан тендерийн баримт бичиг;
5. Тендерт оролцогчдын ирүүлсэн тендер /цахим тендер бол холбогдох файл/;
6. Тендерийн нээлтийн тэмдэглэл;
7. Үнэлгээний хорооны тайлан, хурлын тэмдэглэл;
8. Тендерт оролцогчид болон бусад байгууллагуудтай харилцсан бичиг;
9. Гэрээ байгуулах эрх олгох болон шалгараагүй тухай мэдэгдлийг оролцогч нарт хүргүүлсэн талаар нотлох баримт;
10. Захиалагч хуулийн 54 дүгээр зүйлийн 54.2 дахь хэсэгт заасан гомдол барагдуулах ажиллагаа явуулсан бол холбогдох мэдэгдэл, хурлын тэмдэглэл;
11. Холбогдох бусад баримт бичиг.

9766003824

Түүнчлэн журмын 4.6-д заасны дагуу тендерийн баталгааг чөлөөлөхгүй байх, 4.7-д заасны дагуу тендерт оролцогч нарт гомдол гарсан тухай мэдээлэх арга хэмжээ авахыг үүгээр мэдэгдэж байна.

Гомдлыг хянах хугацаанд хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсэгт заасан тендер шалгаруулалтын хүчинтэй байх хугацаа зогсох болно.

ТӨРИЙН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА



Ж.ГАНБАТ